



ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2022 ОНЫ НЭГДҮГЭЭР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	4
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	7
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	7
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	9
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд...10	
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....10	
2.2.3 “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-т хамрагдсан, уг хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд..11	
2.2.4 “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....12	
2.2.5 Дэлхийн байгаль хамгаалан сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас дэмжин ажиллаж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....13	
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	14
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	14
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	15
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	16
3.4 Зээлийн чанарын талаар.....	17
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	20
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	20
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	21
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	22
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	23
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	23
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	24
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	25
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	25
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	25
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	26
5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-дын талаар.....	26
5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-дын талаар.....	27
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	28
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	28
6.2 Улаанбаатар хотын ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	29
6.3 Орон нутгийн ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	29
6.4 “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	30
ДОЛОО.ДҮГНЭЛТ	31
НАЙМ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР	33

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2022.05.10


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 205 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44 ХЗХ буюу 17.7 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 44.4 хувь буюу 91 ХЗХ орон нутагт, 55.6 хувь буюу 114 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/



Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 5 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 7 ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 7 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 7 ХЗХ-ны 54 сонгуульт гишүүд болон 5 гүйцэтгэх


1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

удирдлага, 1 нягтлан бодогч, 3 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2018	2019	2020	2021	2022.I
ХЗХ-дын тоо	279	261	249	209	205
Шинээр олгосон	18	17	14	-	3
Хүчингүй болгосон	29	35	26	40	7
Түдгэлзүүлсэн	19	10	23	12	7
Сэргээсэн	7	1	6	1	0
ТЗ-ийн хугацаа сунгасан	100	52	49	85	5


Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа



2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 205 ХЗХ 705 ажилтан, 74,966 гишүүн /74,763 иргэн, 203 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 8 дүүрэгт 114 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 ХЗХ буюу 22.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 91 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 3: ХЗХ-дын тархалт



Тайлант улирлын байдлаар нийт 205 ХЗХ 63 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна.

Салбарын тархалтын хувьд 4 ХЗХ-ны 7 салбар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж, 4 ХЗХ-ны 56 салбар орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Үүнд “Гялс төгрөг” ХЗХ-ны 52 салбар Баян-Өлгий аймгаас бусад 19 аймагт тархалттай байна.

График 2: “Гялс төгрөг” ХЗХ-ны салбарын тархалт



1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2022 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 гишүүн буюу 0.05 хувиар буурч 74,966-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.3 хувь буюу 203 хуулийн этгээд, 54.2 хувь буюу 40,606 эмэгтэй гишүүн байна.

Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 58.7 хувь буюу 43,969 гишүүн Улаанбаатар хотод бүртгэлтэй бол 41.3 хувь буюу 30,997 гишүүн орон нутагт бүртгэлтэй байна.

График 3: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурч, 2018-2021 оны 1 дүгээр улирлын байдлаар гишүүдийн тоо тогтмол өсч байсан


хэдий ч тайлант хугацаанд 0.05 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын нийт гишүүдийн 7.5 хувь буюу 5,587 гишүүн “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 54 ХЗХ-ны гишүүд байна.

Мөн тайлант улиралд “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн санхүүжилттэй 28 ХЗХ 10,765 гишүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт 205 ХЗХ-ны 36.6 хувь буюу 75 ХЗХ 20-100 гишүүнтэй, 49.7 хувь буюу 102 ХЗХ 101-500 гишүүнтэй, 9.8 хувь буюу 20 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 3.9 хувь буюу 8 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 8 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 47.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүд	Эзлэх хувь
20-100 гишүүнтэй	75	4,206	5.6%
101-500 гишүүнтэй	102	20,822	27.8%
501-1,000 гишүүнтэй	20	14,397	19.2%
1,001-ээс дээш гишүүнтэй	8	35,541	47.4%
Нийт	205	74,966	100.0%

1.4 Хууль тогтоомжийн өөрчлөлт

- "Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед хадгаламж, зээлийн хоршоодод авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" тогтоолын төслийг танилцуулж, Хорооны 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 22 дугаар тогтоолоор баталсан.
- "ХЗХ-ны үйл ажиллагаанд зайны хяналт болон газар дээрх шалгалт хийх журам"-ын төсөлд сайжруулалт хийж байгаа бөгөөд ХЗХ-дын 2021 оны жилийн эцсийн тайланд үндэслэн эрсдэлд суурилсан зайны хяналтын аргачлалыг туршиж байна.
- ХЗХ-дын улирлын санхүүгийн тайлан шивж илгээх, мастерфайлыг илгээхэд гардаг түгээмэл алдаануудын талаар 8 видео бичлэг хийж, 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Хорооны сайтад байршуулж олон нийтэд мэдээлсэн.
- 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Зээлийн мэдээллийн сангийн программын асуудлаар "TITAN CRA" ХХК-ийн удирдлагуудтай ББСБГ-ын төлөөллийн хамт уулзаж санал солилцсон. Уулзалтын дагуу тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дод Хорооны 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 8/1121 тоот албан бичгээр Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А-264, А-265 дугаар тушаалаар "Бүрэн скор ЗМС" ХХК, "Титан Си Ар Эй ЗМС" ХХК-д Зээлийн мэдээллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан үйл ажиллагааг эрхлэхээр тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасны дагуу зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон тул Зээлийн мэдээллийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7-д "банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээг байгуулж, мэдээлэл солилцох үүрэг хүлээх" гэж заасны дагуу дээр дурдсан компаниудтай хамтран ажиллах талаар мэдээллийг хүргүүлсэн.
- 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Сангийн яамны НБББГ-ын ахлах шинжээч Б.Болормаатай цахимаар уулзаж, Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн журмыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх боломжийн талаар санал солилцсон.
- СЗХ-ноос ЕСБХБ-тай хамтран ажиллах 2022-2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 28, 02 дугаар сарын 15-ны өдөр Төв Азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд төслийн удирдах зөвлөлийн хуралд оролцож банкнаас бусад санхүүгийн зах зээлд дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар мэдээлэл өгсөн.
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаатай холбоотойгоор Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабалд мэдээлэл хүсэх тухай 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 1/935 тоот албан бичгийг хүргүүлсэн. Уг албан бичгийн дагуу 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газрын дарга, холбогдох албан хаагчидтай уулзаж, ХЗХ-ны албан татвартай холбогдох асуудлаар санал солилцсон.

- 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Зээлийн батлан даалтын сан, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны төлөөллүүд уулзаж Хадгаламж, зээлийн хоршоодыг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах боломж, хууль эрх зүйн орчны талаар болон хоршооны гишүүн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийг батлан даах асуудлаар харилцан санал, мэдээлэл солилцсон. Уг уулзалтаар 3 байгууллагын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулж, Хадгаламж, зээлийн хоршоодыг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах, цаашлаад гишүүн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийг батлан даах боломжийг судлах, боломжит шийдлийг тодорхойлж, хамтран ажиллахаар тогтсон.
- 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Бичил санхүүгийн зах зээлээр БЖДҮ-ийн зээл дамжуулах болон холбогдох бусад асуудлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөлтэй, ББСБГ-ын даргын хамт уулзаж санал солилцсон. Ажлын хэсэг байгуулж, хамтран ажиллахаар тохирсон.
- “Монголын эдийн засгийн форум-2022” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2022 оны 3 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ногоон санхүүжилт бүс нутгийн чуулган”-д МХЗХҮХ-ны төлөөлөл оролцож, 2030 он хүртэлх хугацаанд ХЗХ-д болон

гишүүдтэйгээ хамтран 1,250,000 /нэг сая хоёр зуун тавин мянга/ ширхэг мод тарих амлалт өгч, түүчээлэн ажиллахаар санамж бичигт гарын үсэг зурж, батламж авсан.

Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт зээлдэгч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	205	100.0%	114	55.6%	91	44.4%
Нийт зээлийн үлдэгдэл	219,286,946.74	100.0%	173,391,475.20	79.1%	45,895,471.54	20.9%
Нийт зээлдэгчийн тоо	35,396	100.0%	18,860	53.3%	16,536	46.7%
Иргэн	35,316	99.8%	18,798	99.7%	16,518	99.9%
Эмэгтэй	19,042	53.8%	10,324	54.7%	8,718	52.7%
Хуулийн этгээд	80	0.2%	62	0.3%	18	0.1%
Зээлдэгчдийн насжилт	35,316	100.0%	18,798	53.2%	16,518	46.8%
18-35 насны	9,608	27.2%	5,903	31.4%	3,705	22.4%
36-45 насны	11,144	31.6%	6,410	34.1%	4,734	28.7%
46-55 насны	9,677	27.4%	5,178	27.5%	4,499	27.2%
55-аас дээш	4,887	13.8%	1,307	7.0%	3,580	21.7%
Зээлдэгчдийн боловсрол	35,316	100.0%	18,798	53.2%	16,518	46.8%
Дээд	12,161	34.4%	7,218	38.4%	4,943	29.9%
Тусгай дунд	7,805	22.1%	4,974	26.5%	2,831	17.1%
Бүрэн дунд	8,940	25.3%	3,954	21.0%	4,986	30.2%
Дунд	5,049	14.3%	2,568	13.7%	2,481	15.0%
Бага	361	3.9%	84	0.4%	1,277	7.7%

Тайлант улиралд ХЗХ-д 35,396 зээлдэгчийн 219,286,946.74 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 53.3 хувь буюу 18,860 зээлдэгч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 79.1 хувь буюу 173,391,475.20 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 46.7 хувь буюу 16,536 зээлдэгч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 20.9 хувь буюу 45,895,471.54 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.8 хувь буюу 35,316 нь хувь хүн, үүнээс 53.8 хувь буюу 19,042 нь эмэгтэй, 0.2 хувь буюу 80 нь хуулийн этгээд байна.

Нийт зах зээлийн хувьд 1 зээлдэгчид ногдох дундаж зээл 6,195.25 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 9,193.61 мянган төгрөг, орон нутагт 2,775.49 мянган төгрөг байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	205	100.0%	114	55.6%	91	44.4%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	202,110,148.25	100.0%	165,520,910.79	81.9%	36,589,237.45	18.1%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	37,296	100.0%	19,621	52.6%	17,675	47.4%
Эмэгтэй	20,015	53.7%	10,394	53.0%	9,621	54.4%
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	3,332,786.78	1.6%	2,849,364.30	1.7%	483,422.48	1.3%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	3,816	10.2%	2,756	14.0%	1,060	6.0%
Иргэн	3,796	10.2%	2,738	13.9%	1,058	6.0%
Хуулийн этгээд	20	0.1%	18	0.1%	2	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	198,777,361.47	98.4%	162,671,546.49	98.3%	36,105,814.97	98.7%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	33,480	89.8%	16,865	86.0%	16,615	94.0%
Иргэн	33,433	89.6%	16,856	85.9%	16,577	93.8%
Хуулийн этгээд	47	0.1%	9	0.0%	38	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	37,229	100.0%	19,594	52.6%	17,635	47.4%
18-35 насны	12,668	34.0%	7,916	40.4%	4,752	26.9%
36-45 насны	10,461	28.1%	5,385	27.5%	5,076	28.8%
46-55 насны	8,022	21.5%	3,776	19.3%	4,246	24.1%

55-аас дээш	6,078	16.3%	2,517	12.8%	3,561	20.2%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	37,229	100.0%	19,594	52.6%	17,635	47.4%
Дээд	17,675	47.5%	12,478	63.7%	5,197	29.5%
Тусгай дунд	5,032	13.5%	2,439	12.4%	2,593	14.7%
Бүрэн дунд	8,189	22.0%	3,121	15.9%	5,068	28.7%
Дунд	3,931	10.6%	918	4.7%	3,013	17.1%
Бага	2,402	6.5%	638	3.3%	1,764	10.0%

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 37,296 хадгаламж эзэмшигчийн 202,110,148.25 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 52.6 хувь буюу 19,621 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 81.9 хувь буюу 165,520,910.79 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 47.4 хувь буюу 17,675 хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 18.1 хувь буюу 36,589,237.45 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Нийт хадгаламж

эзэмшигчийн 10.2 хувийг хугацаагүй хадгаламжтай, 89.8 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 37,229 нь хувь хүн /үүний 53.8 хувь буюу 20,015 нь эмэгтэй/, 0.2 хувь буюу 67 нь хуулийн этгээд байна.

Нийт зах зээлийн 1 хадгаламж, эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,419.1 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 8,435.91 мянган төгрөг, орон нутагт 2,070.11 мянган төгрөг байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 291,292,672.35 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.4 хувь буюу 12,357,786.87 мянган төгрөгөөр өсөж банкны зах зээлийн 0.7 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 14.2 хувь буюу 27,220,885.22 мянган төгрөг,

нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 0.4 хувь буюу 758,681.19 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 13.9 хувь буюу 1,993,048.11 мянган төгрөг, нийт зарлага 2.8 хувь буюу 356,522.71 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр нийт цэвэр орлого 104.9 хувь буюу 1,636,525.40 мянган төгрөгөөр нэмэгдэж 3,196,777.41 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны I улирал	2022 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	278,934,885.48	291,292,672.35		
Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.7%	12,357,786.87	4.4%
Нийт зээл	192,066,061.51	219,286,946.73		
Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.0%	27,220,885.22	14.2%
Нийт чанаргүй зээл	6,986,906.18	7,038,883.68		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.6%	3.2%	51,977.50	0.7%
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.3%	-0.4%	-11.8%
			0.0%	-4.2%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	201,351,467.05	202,110,148.24		
Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.2%	758,681.19	0.4%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	21,324,485.71	26,397,988.26		
Нийт хоршоологчдын өмч	29,597,084.38	39,123,488.67		
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	7,493,925.79	3,916,726.46	5,073,502.55	23.8%
			9,526,404.29	32.2%
			-3,577,199.33	-47.7%

Нийт орлого	14,313,542.23	16,306,590.34	1,993,048.11	13.9%
Нийт зарлага	12,753,290.22	13,109,812.93	356,522.71	2.8%
Цэвэр орлого, алдагдал	1,560,252.01	3,196,777.41	1,636,525.40	104.9%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 114 ХЗХ-ны нийт хөрөнгө 237,520,386.27 мянган төгрөг нь зах зээлийн 81.5 хувь, нийт зээл 173,391,475.20 мянган төгрөг нь зах зээлийн 79.1 хувь, нийт хадгаламж 165,520,910.79 мянган төгрөг нь зах зээлийн 81.9 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 хувь буюу 138,023.05 мянган төгрөгөөр буурч 6,276,049.27 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.6 хувийг эзэлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс

авсан зээл өмнөх оны мөн үеэс 47.3 хувь буюу 3,446,288.43 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 8.5 хувь буюу 967,568.47 мянган төгрөгөөр өссөн, нийт зарлага 4.0 хувь буюу 418,601.30 мянган төгрөгөөр буурч, нийт цэвэр орлого 137.1 хувь буюу 1,386,169.77 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Улаанбаатар хотын 78 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны I улирал	2022 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	236,260,011.36	237,520,386.27	1,260,374.91	0.5%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	84.7%	81.5%	-3.2%	-3.7%
Нийт зээл	159,182,749.49	173,391,475.20	14,208,725.71	8.9%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	82.9%	79.1%	-3.8%	-4.6%
Нийт чанаргүй зээл	6,414,072.32	6,276,049.27	-138,023.05	-2.2%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	91.8%	89.2%	-2.6%	-2.9%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.0%	3.6%	-0.4%	-10.2%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	172,586,560.42	165,520,910.79	-7,065,649.63	-4.1%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	85.7%	81.9%	-3.8%	-4.5%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	15,669,377.12	19,845,383.49	4,176,006.37	26.7%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	73.5%	75.2%	1.7%	2.3%
Нийт хоршоологчдын өмч	23,965,944.33	31,897,414.01	7,931,469.68	33.1%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	81.0%	81.5%	0.6%	0.7%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	7,286,914.90	3,840,626.47	-3,446,288.43	-47.3%
Нийт орлого	11,376,417.84	12,343,986.31	967,568.47	8.5%
Нийт зарлага	10,365,015.69	9,946,414.39	-418,601.30	-4.0%
Цэвэр орлого, алдагдал	1,011,402.15	2,397,571.92	1,386,169.77	137.1%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 91 ХЗХ-ны нийт хөрөнгө 53,772,286.08 мянган төгрөг нь зах зээлийн 18.5 хувь, нийт зээлийн үлдэгдэл 45,895,471.54 мянган төгрөг нь зах зээлийн 20.9 хувь, нийт хадгаламж 36,589,237.45 мянган төгрөг нь зах зээлийн 18.1 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 34.9 хувь

буюу 1,025,479.65 мянган төгрөг, нийт зарлага 32.5 хувь буюу 775,124.01 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, цэвэр орлого 45.6 хувь буюу 250,335.64 мянган төгрөгөөр нэмэгдэж 799,205.50 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн 30 ХЗХ “Монголбанкны

зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны I улирал	2022 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	42,674,874.12	53,772,286.08	11,097,411.96	26.0%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	15.3%	18.5%	3.2%	20.7%
Нийт зээл	32,883,312.01	45,895,471.54	13,012,159.53	39.6%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	17.1%	20.9%	3.8%	22.2%
Нийт чанаргүй зээл	572,833.87	762,834.41	190,000.54	33.2%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	8.2%	10.8%	2.6%	32.2%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.4%	0.4%	0.1%	22.3%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	28,764,906.63	36,589,237.45	7,824,330.82	27.2%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	14.3%	18.1%	3.8%	26.7%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	5,655,108.59	6,552,604.77	897,496.18	15.9%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	26.5%	24.8%	-1.7%	-6.4%
Нийт хоршоологчдын өмч	5,631,140.06	7,226,074.66	1,594,934.60	28.3%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	19.0%	18.5%	-0.6%	-2.9%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	207,010.89	76,100.00	-130,910.89	-63.2%
Нийт орлого	2,937,124.39	3,962,604.04	1,025,479.65	34.9%
Нийт зарлага	2,388,274.53	3,163,398.54	775,124.01	32.5%
Цэвэр орлого, алдагдал	548,849.86	799,205.50	250,355.64	45.6%

2.2.3 “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд шинээр байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Тайлант улиралд 54 ХЗХ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27 ХЗХ буюу 33.3 хувиар буурсан байна. Төсөл хөтөлбөрийн ХЗХ-дын нийт хөрөнгө 5,688,329.34 мянган төгрөг нь зах зээлийн 2.0 хувь, нийт зээл 4,580,233.40 мянган төгрөг нь зах зээлийн 2.1 хувь, нийт хадгаламж 1,894,720.00 мянган төгрөг нь зах зээлийн 0.9 хувийг тус тус эзэлж байна. Тайлант улиралд банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 1,806,659.74 мянган төгрөгт хүрснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56.7 хувь буюу 2,364,271.16 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.4

хувь буюу 69,966.92 мянган төгрөг, нийт зарлага 20.3 хувь буюу 90,713.29 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Тайлант улиралд 2,047.06 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ.

Хөтөлбөрийн хүрээнд зээлийн санхүүжилт олгосон ХЗХ-доос 22.2 хувь буюу 12 ХЗХ төслийн зээлийг бүрэн төлж дууссан байна. Зээлийн үлдэгдэлтэй 42 ХЗХ төсөл, хөтөлбөрөөс авсан зээлийн үлдэгдлийг тайлант улиралд 29,658.80 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан бөгөөд 20 ХЗХ нийт 41,546.19 мянган төгрөгийн зээлийг дутуу тайлагнаж, 12 ХЗХ зээлийн үлдэгдлийг богино хугацаат зээлийн ангилалд бүртгэсэн байна.

Хүснэгт 9: Нийслэлийн төсөл хөтөлбөрийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны I улирал	2022 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	7,815,855.18	5,688,329.34	-2,127,525.84	-27.2%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	2.8%	2.0%	-0.8%	-30.3%
Нийт зээл	6,327,888.00	4,580,233.40	-1,747,654.60	-27.6%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	3.3%	2.1%	-1.2%	-36.6%
Нийт чанаргүй зээл	441,439.99	188,320.83	-253,119.16	-57.3%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	6.3%	2.7%	-3.6%	-57.7%

Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	7.0%	4.1%	-2.9%	-41.1%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	1,995,451.57	1,894,720.00	-100,731.57	-5.0%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	1.0%	0.9%	-0.1%	-5.4%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	741,792.45	582,799.12	-158,993.33	-21.4%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	3.5%	2.2%	-1.3%	-36.5%
Нийт хоршоологчдын өмч	385,095.32	505,114.08	120,018.76	31.2%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	1.3%	1.3%	0.0%	-0.8%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	4,170,930.90	1,806,659.74	-2,364,271.16	-56.7%
Нийт орлого	427,927.16	357,960.24	-69,966.92	-16.4%
Нийт зарлага	446,626.47	355,913.18	-90,713.29	-20.3%
Цэвэр орлого, алдагдал	-18,699.31	2,047.06	20,746.37	110.9%

2.2.4 “Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 10: “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны I улирал	2022 оны I улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	9,891,126.15	13,674,252.65	3,783,126.50	38.2%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	3.5%	4.7%	1.1%	32.4%
Нийт зээл	7,874,050.14	11,955,554.25	4,081,504.11	51.8%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	4.1%	5.5%	1.4%	33.0%
Нийт чанаргүй зээл	87,944.23	105,984.32	18,040.09	20.5%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	1.3%	1.5%	0.2%	19.6%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	1.1%	0.9%	-0.2%	-20.6%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	6,879,926.31	9,714,407.18	2,834,480.87	41.2%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	3.4%	4.8%	1.4%	40.7%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	1,227,064.11	1,422,669.93	195,605.82	15.9%
ХЗХ-ны нийт хувь хөрөнгөд эзлэх хувь	5.8%	5.4%	-0.4%	-6.3%
Нийт хоршоологчдын өмч	808,673.99	1,321,951.08	513,277.09	63.5%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	2.7%	3.4%	0.6%	23.7%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	130,833.71	46,100.00	-84,733.71	-64.8%
Нийт орлого	650,011.98	924,524.04	274,512.06	42.2%
Нийт зарлага	492,660.19	681,456.75	188,796.56	38.3%
Цэвэр орлого, алдагдал	157,351.79	243,067.29	85,715.50	54.5%

Төслийн санхүүжилттэй 28 ХЗХ-ны гишүүдийн тоо 10,765 буюу зах зээлийн нийт гишүүдийн 14.4 хувийг эзэлж байна. Тус ХЗХ-дын нийт хөрөнгө 13,674,252.65 мянган төгрөг нь зах зээлийн 4.7 хувь, нийт зээл 11,955,554.25 мянган төгрөг нь зах зээлийн 5.5 хувь, нийт хадгаламж 9,714,407.18 мянган төгрөг нь зах зээлийн 4.8 хувийг тус тус эзэлж байна. Тайлант улиралд банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс

авсан зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 64.8 хувь буюу 84,733.71 мянган төгрөгөөр буурч 46,100.00 мянган төгрөгт хүржээ. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 42.2 хувь буюу 274,512.06 мянган төгрөгөөр, нийт зарлага 38.3 хувь буюу 188,796.56 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээр цэвэр орлого 54.5 хувь буюу 85,715.50 мянган төгрөгөөр өсөж 243,067.29 мянган төгрөгт хүрсэн байна.

2.2.5 Дэлхийн байгаль хамгаалан сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас дэмжин ажиллаж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас дэмжин ажиллаж буй 12 ХЗХ-ны гишүүдийн тоо 3,409 буюу зах зээлийн нийт гишүүдийн 4.5 хувийг эзэлж байна. Тус ХЗХ-дын нийт хөрөнгө 3,954,998.78 мянган төгрөг нь зах зээлийн 1.4 хувь, нийт зээл 3,613,749.08 мянган төгрөг нь зах зээлийн 1.6 хувь, нийт хадгаламж 2,732,588.80 мянган төгрөг нь зах зээлийн 1.4 хувийг тус тус эзэлж байна. Тайлант улиралд банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 46,100.00 мянган төгрөг байгаа бол нийт орлого 287,606.72 мянган төгрөг, нийт зарлага 199,722.47 мянган төгрөг, цэвэр орлого 87,884.25 мянган төгрөг байна.

Уг ХЗХ-дын 75.0 хувь буюу 9 ХЗХ “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төсөлд хамрагдсан байна.

Хүснэгт 11: Дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжин ажиллаж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2022 оны I улирал
Нийт хөрөнгө	3,954,998.78
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	1.4%
Нийт зээл	3,613,749.08
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	1.6%
Нийт чанаргүй зээл	54,294.75
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	0.8%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	1.5%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	2,732,588.80
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	1.4%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	394,648.39
ХЗХ-ны нийт хувь хөрөнгөд эзлэх хувь	1.5%
Нийт хоршоологчдын өмч	463,047.82
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	1.2%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	46,100.00
Нийт орлого	287,606.72
Нийт зарлага	199,722.47
Цэвэр орлого, алдагдал	87,884.25

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 12: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2021 оны I улирал		2022 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	271,551,440.44	97.4%	280,350,566.01	96.2%	8,799,125.57	3.2%
Мөнгөн хөрөнгө	73,619,936.59	26.4%	51,208,991.71	17.6%	-22,410,944.88	-30.4%
Бэлэн мөнгө	4,530,196.38	1.6%	7,529,826.05	2.6%	2,999,629.67	66.2%
Банкинд байршуулсан харилцах	20,058,679.83	7.2%	7,219,702.95	2.5%	-12,838,976.88	-64.0%
Банкинд байршуулсан хадгаламж	49,031,060.39	17.6%	36,459,462.72	12.5%	-12,571,597.67	-25.6%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	150,000.00	0.1%	150,000.00	0.1%	0.00	0.0%
Арилжааны үнэт цаас	150,000.00	0.1%	150,000.00	0.1%	0.00	0.0%
Зээл /цэврээр/	186,969,058.63	67.0%	213,675,151.76	73.4%	26,706,093.13	14.3%
Нийт зээл	192,066,061.51	68.9%	219,286,946.74	75.3%	27,220,885.23	14.2%
Хэвийн зээл	179,521,742.67	64.4%	206,922,852.69	71.0%	27,401,110.02	15.3%
Хугацаа хэтэрсэн зээл	5,557,412.65	2.0%	5,325,210.37	1.8%	-232,202.28	-4.2%
Чанаргүй зээл	6,986,906.18	2.5%	7,038,883.68	2.4%	51,977.50	0.7%
(Зээлийн эрсдэлийн сан)	5,097,002.88	1.8%	5,611,794.98	1.9%	514,792.10	10.1%
Авлага	9,304,641.47	3.3%	11,683,114.49	4.0%	2,378,473.02	25.6%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	778,749.49	0.3%	1,450,332.96	0.5%	671,583.47	86.2%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,525,891.98	3.1%	10,232,781.54	3.5%	1,706,889.56	20.0%
Бусад эргэлтийн хөрөнгө	720,639.37	0.3%	2,967,519.25	1.0%	2,246,879.88	311.8%
Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр/	787,164.39	0.3%	665,788.79	0.2%	-121,375.60	-15.4%
Өмчлөх бусад хөрөнгө	793,242.74	0.3%	704,102.11	0.2%	-89,140.63	-11.2%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	6,078.35	0.0%	38,313.32	0.0%	32,234.97	530.3%
Эргэлтийн бус хөрөнгө	7,383,445.04	2.6%	10,942,106.34	3.8%	3,558,661.30	48.2%
Үндсэн хөрөнгө /цэвэр/	4,303,600.88	1.5%	3,723,623.30	1.3%	-579,977.58	-13.5%
Үндсэн хөрөнгө	6,083,164.46	2.2%	5,781,841.65	2.0%	-301,322.81	-5.0%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,779,563.58	0.6%	2,058,218.35	0.7%	278,654.77	15.7%
Биет бус хөрөнгө	3,064,356.36	1.1%	7,202,995.25	2.5%	4,138,638.89	135.1%
Биет бус хөрөнгө	3,143,098.46	1.1%	7,283,372.66	2.5%	4,140,274.20	131.7%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	78,742.09	0.0%	80,377.41	0.0%	1,635.32	2.1%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,487.79	0.0%	15,487.79	0.0%	0.00028	0.0%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,487.79	0.0%	15,487.79	0.0%	0.00028	0.0%
Хөрөнгийн дүн	278,934,885.48	100.0%	291,292,672.35	100.0%	12,357,786.87	4.4%

Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/



2022 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 291,292,672.35 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.4 хувь буюу 12,357,786.87 мянган төгрөгөөр өссөн


үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 96.2 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.8 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 17.6 хувийг, цэвэр зээл 73.4 хувийг тус тус эзэлж байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.2 хувь буюу 27,220,885.23 мянган төгрөгөөр өсөж 219,286,946.74 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 5,611,794.98 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 213,675,151.76 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.2 хувь буюу 232,202.28

мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 183,536,465.58 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 63.0 хувийг, гишүүдийн тоо 24,590 байгаа нь нийт гишүүдийн 32.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 13: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө			
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	183,536,465.58	63.0%	24,590	32.8%
2	1,000,000.0 -10,000,000.0	25	73,620,175.13	25.3%	22,844	30.5%
3	500,000.0-1,000,000.0	19	12,946,075.86	4.4%	7,896	10.5%
4	100,000.0-500,000.0	77	16,482,547.80	5.7%	13,219	17.6%
5	50,000.0-100,000.0	50	3,755,213.34	1.3%	4,686	6.3%
6	10,000.0-50,000.0	29	944,745.51	0.3%	1,706	2.3%
7	10,000.0 хүртэл	1	7,449.13	0.00%	25	0.0%
Нийт дүн		205	291,292,672.35	100.0%	74,966	100.0%



1 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгөтэй 29 ХЗХ байгаагаас “Монкорд” ХЗХ нь хууль, хяналтын байгууллагад шалгагдаж байна. Бусад 28 ХЗХ-ны мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 14: 1 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй ХЗХ-дын мэдээлэл /мянган төгрөгөөр/

№	ХЗХ-ны нэрс	Гишүүдийн тоо	Хөрөнгийн дүн	Нийт хөрөнгөд эзлэх хувь	Нийт зээл	Хадгаламж	Тайлант үеийн цэвэр орлого
1.	Номин юнион	5,947	105,822,262.39	36.3%	78,300,803.28	77,249,515.09	1,783,257.26
2.	Гялс төгрөг	15,395	32,039,585.37	11.0%	20,860,026.86	21,819,312.18	-20,807.78
3.	Ард актив	2,542	31,950,566.03	11.0%	22,987,311.88	22,600,841.05	137,927.40
4.	Сидан	706	13,724,051.79	4.7%	9,590,031.04	10,665,918.29	-8,013.06
5.	Арвайн үр	431	7,808,926.65	2.7%	5,866,860.62	5,732,180.38	76,678.40
6.	Малчны хөгжил*	3,340	5,406,740.03	1.9%	4,595,582.27	4,315,389.02	56,295.73
7.	Эмпипи*	1561	5,263,564.37	1.8%	4,557,564.40	3,989,358.37	2,251.24
8.	Кредит юнион монгол	1,453	4,959,052.70	1.7%	4,077,453.11	4,087,249.88	21,928.90
9.	Алтан давалгаа	854	4,720,922.00	1.6%	3,843,737.35	3,732,060.77	45,074.62
10.	Бэх*	946	4,409,898.41	1.5%	4,091,255.53	2,085,900.13	49,759.15
11.	Мон сант алдар	928	4,407,492.21	1.5%	3,853,119.29	3,422,169.67	252.89
12.	Цэнгэл хөгжил*	1932	4,063,112.11	1.4%	3,593,262.78	2,858,254.60	30,226.76
13.	Хас баяжих*	947	2,856,840.03	1.0%	2,231,824.55	2,123,886.23	122,388.01

14.	Май капитал	240	2,755,723.98	0.9%	2,105,173.53	1,248,078.10	71,959.01
15.	Өгийн мандал*	665	2,733,255.77	0.9%	2,538,015.47	2,138,885.22	44,280.35
16.	Инвест Өлгий*	870	2,712,289.92	0.9%	1,972,508.31	2,062,293.75	17,604.16
17.	Арвин дэм	577	1,972,350.97	0.7%	1,617,329.06	1,243,660.84	23,353.44
18.	Сүлдэт Өндөр*	825	1,795,042.42	0.6%	1,625,533.47	1,429,465.95	27,645.45
19.	Хөгжилд тэмүүлэх сугай*	545	1,405,332.65	0.5%	1,335,721.12	1,102,538.72	26,038.46
20.	Ант инвест	112	1,393,814.26	0.5%	1,096,308.37	855,912.77	65,333.95
21.	Гэмбл	360	1,375,602.95	0.5%	583,090.24	513,644.38	23,963.45
22.	Ногоон алт финанс	162	1,325,217.95	0.5%	993,079.25	908,792.35	35,827.46
23.	Баян хайрхан хас*	644	1,286,617.24	0.4%	1,086,365.84	631,814.26	33,574.10
24.	Монум	344	1,208,355.66	0.4%	1,088,354.35	421,636.93	25,083.10
25.	Алдияр*	770	1,138,175.47	0.4%	981,056.90	587,937.52	48,644.85
26.	Тэгш боломж	524	1,061,119.38	0.4%	928,761.63	843,588.41	13,119.45
27.	Өгөөдэй зоос	90	1,049,360.45	0.4%	910,022.06	698,423.21	22,673.19
28.	Ирээдүйн зорилт	353	1,003,824.27	0.3%	343,834.68	352,891.81	14,607.85
28 ХЗХ-ны нийт дүн		44,063	251,649,097.44	86.4%	187,653,987.22	179,721,599.87	2,790,927.79
Бусад 177 ХЗХ		30,903	39,643,574.91	13.6%	31,632,959.520	22,388,548.38	405,849.63
Нийт дүн		74,966	291,292,672.35	100.0%	219,286,946.74	202,110,148.25	3,196,777.42

*орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ

Зах зээлийн нийт хөрөнгийн 86.4 хувийг дээрх 28 ХЗХ-ны хөрөнгө эзэлж байгаа бол үүнээс 11 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 219,286,946.74 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 75.3 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 213,675,151.76 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 73.4 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.1 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 23 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 85.1 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тайлант улиралд 1 ХЗХ

зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна /2022 оны 1 дүгээр сард тусгай зөвшөөрөл авсан “Далай хишиг финанс” ХЗХ/.

Хүснэгт 15: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	23	186,622,941.29	85.1%
2	500,000.0-1,000,000.0	19	13,179,743.73	6.0%
3	100,000.0-500,000.0	67	14,696,750.97	6.7%
4	50,000.0-100,000.0	46	3,317,267.38	1.5%
5	10,000.0-50,000.0	44	1,427,239.56	0.7%
6	10,000.0 хүртэл	5	43,003.80	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	1	-	-
Нийт дүн		205	219,286,946.74	100%

1 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний зээлтэй 23 ХЗХ-оос “Монкорд” ХЗХ нь хууль, хяналтын байгууллагад шалгагдаж байна. Бусад 22 ХЗХ-ны мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 16: 1 тэрбум төгрөгөөс дээш зээлтэй ХЗХ-дын мэдээлэл /мянган төгрөгөөр/

№	ХЗХ-дын нэрс	Зээлийн дүн	Нийт зээлд эзлэх хувь	Тухайн ХЗХ-ны хөрөнгөд зээлийн эзлэх хувь
1	Номин юнион	78,300,803.28	35.7%	74.0%
2	Ард актив	22,987,311.88	10.5%	71.9%
3	Гялс төгрөг	20,860,026.86	9.5%	65.1%
4	Сидан	9,590,031.04	4.4%	69.9%
5	Арвайн үр	5,866,860.62	2.7%	75.1%
6	Малчны хөгжил	4,595,582.27	2.1%	85.0%
7	Эмпипи	4,557,564.40	2.1%	86.6%
8	Бэх	4,091,255.53	1.9%	92.8%
9	Кредит юнион монгол	4,077,453.11	1.9%	82.2%

10	Мон сант алдар	3,853,119.29	1.8%	87.4%
11	Алтан давалгаа	3,843,737.35	1.8%	81.4%
12	Цэнгэл хөгжил	3,593,262.78	1.6%	88.4%
13	Өгийн мандал	2,538,015.47	1.2%	92.9%
14	Хас баяжих	2,231,824.55	1.0%	78.1%
15	Май капитал	2,105,173.53	1.0%	76.4%
16	Инвест Өлгий	1,972,508.31	0.9%	72.7%
17	Сүлдэт Өндөр	1,625,533.47	0.7%	90.6%
18	Арвин дэм	1,617,329.06	0.7%	82.0%
19	Хөгжилд тэмүүлэх сугай	1,335,721.12	0.6%	95.0%
20	Ант инвест	1,096,308.37	0.5%	78.7%
21	Монум	1,088,354.35	0.5%	90.1%
22	Баян хайрхан хас	1,086,365.84	0.5%	84.4%
Нийт		182,914,142.47	83.4%	-
Бусад 183 ХЗХ		36,372,804.27	16.6%	-
Нийт дүн		219,286,946.74	100.0%	-

*орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа ХЗХ

Зээлийн дүн өндөртэй ХЗХ-дын зээлийн хувь хэмжээ тухайн ХЗХ-ны нийт хөрөнгийн 65.1-95.0 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг 85 ХЗХ буюу 41.5 хувь нь хангахгүй байна. Нийт зээлийн дүн өндөр ХЗХ-дын 10 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 17: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	35,396	100.0%	219,286,946.74	100.0%
Хэвийн	32,869	92.9%	206,922,852.69	94.4%
Хугацаа хэтэрсэн	1,243	3.5%	5,325,210.37	2.4%
Чанаргүй	1,284	3.6%	7,038,883.68	3.2%
<i>Хэвийн бус</i>	474	36.9%	1,759,973.36	25.0%
<i>Эргэлзээтэй</i>	299	23.3%	929,934.98	13.2%
<i>Муу</i>	511	39.8%	4,348,975.34	61.8%

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 94.4 хувь буюу 206,922,852.69 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.4 хувь буюу 5,325,210.37 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.2 хувь буюу 7,038,883.68 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 12,364,094.05 мянган төгрөгийн үлдэгдэлд 45.4 хувь буюу 5,611,794.98

мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.9 хувийг хэвийн, 3.5 хувийг хугацаа хэтэрсэн, 3.6 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,284 зээлдэгчийн 7,038,883.68 мянган төгрөгийн үлдэгдлийн 36.9 хувийг хэвийн бус, 23.3 хувийг эргэлзээтэй, 39.8 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

График 8: Зээлийн чанар



Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 пунктээр өсөж 94.4 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 0.5 пунктээр буурч 2.4 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.4 пунктээр буурч 3.2 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 18: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
Нийт	173,391,475.20	100.0%	79.1%	45,895,471.54	100.0%	20.9%
Хэвийн	162,936,465.61	94.0%	78.7%	43,986,387.08	95.8%	21.3%
Хугацаа хэтэрсэн	4,178,960.32	2.4%	78.5%	1,146,250.05	2.5%	21.5%
Чанаргүй	6,276,049.27	3.6%	89.2%	762,834.41	1.7%	10.8%
<i>Хэвийн бус</i>	<i>1,324,954.51</i>	<i>21.1%</i>	<i>75.3%</i>	<i>435,018.85</i>	<i>57.0%</i>	<i>24.7%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>809,592.26</i>	<i>12.9%</i>	<i>87.1%</i>	<i>120,342.72</i>	<i>15.8%</i>	<i>12.9%</i>
<i>Муу</i>	<i>4,141,502.50</i>	<i>66.0%</i>	<i>95.2%</i>	<i>207,472.84</i>	<i>27.2%</i>	<i>4.8%</i>

Зээлийн ангиллын мэдээллийг хот, орон нутгаар ангилан харвал ХЗХ-ны зах зээлийн нийт зээлийн 79.1 хувь буюу 173,391,475.20 мянган төгрөгийг Улаанбаатар хотын ХЗХ-д, 20.9 хувь буюу 45,895,471.54 мянган төгрөгийг орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 94.0 хувь буюу 162,936,465.61 мянган төгрөгийг хэвийн, 2.4 хувь буюу 4,178,960.32 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 3.6 хувь буюу 6,276,049.27 мянган төгрөгийн чанаргүй

зээлийн үлдэгдэл эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдлийн 66.0 хувь буюу 4,141,502.5 мянган төгрөгийг муу зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа бөгөөд зах зээлийн нийт муу зээлийн 95.2 хувийг эзэлж байна. Орон нутгийн ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 95.8 хувь буюу 43,986,387.08 мянган төгрөгийг хэвийн, 2.5 хувь буюу 1,146,250.05 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 1.7 хувь буюу 762,834.41 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 19: Зээлийн ангиллын мэдээлэл төсөл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Нийслэлийн хөтөлбөрийн ХЗХ-д			Ногоон алт төслийн ХЗХ-д		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
Нийт	4,580,233.40	100.0%	2.1%	11,955,554.25	100.0%	5.5%
Хэвийн	4,094,304.16	89.4%	2.0%	11,725,607.29	98.1%	5.7%
Хугацаа хэтэрсэн	297,608.41	6.5%	5.6%	123,962.64	1.0%	2.3%
Чанаргүй	188,320.83	4.1%	2.7%	105,984.32	0.9%	1.5%
<i>Хэвийн бус</i>	<i>61,999.78</i>	<i>32.9%</i>	<i>3.5%</i>	<i>54,241.10</i>	<i>51.2%</i>	<i>3.1%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>84,684.29</i>	<i>45.0%</i>	<i>9.1%</i>	<i>42,439.73</i>	<i>40.0%</i>	<i>4.6%</i>
<i>Муу</i>	<i>41,636.76</i>	<i>22.1%</i>	<i>1.0%</i>	<i>9,303.49</i>	<i>8.8%</i>	<i>0.2%</i>


Зээлийн ангиллын мэдээллийг төсөл, хөтөлбөрөөр ангилан харвал “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 89.4 хувь буюу 4,094,304.16

мянган төгрөгийг хэвийн, 6.5 хувь буюу 297,608.41 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн, 4.1 хувь буюу 188,320.83 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн хүрээнд байгуулагдсан

ХЗХ-дын зээлийн үлдэгдлийн 98.1 хувь буюу 11,725,607.29 мянган төгрөгийг хэвийн, 1.0 хувь буюу 123,962.64 мянган

төгрөгийг хугацаа хэтэрсэн, 0.9 хувь буюу 105,984.32 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл эзэлж байна.

График 9: Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Хүснэгт 20: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6,208,070.80	3,463,310.62	2,252,860.09	7,418,521.34	3.4%
2	Уул уурхай, олборлолт	2,110,201.46	509,700.00	762,500.25	1,857,401.21	0.8%
3	Боловсруулах үйлдвэрлэл	1,532,570.78	1,032,985.75	479,366.84	2,086,189.70	1.0%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	296,243.93	145,153.00	101,007.56	340,389.38	0.2%
5	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	465,213.56	73,000.00	89,224.15	448,989.41	0.2%
6	Барилга	7,181,256.16	3,019,120.00	2,533,120.61	7,667,255.56	3.5%
7	Бөөний болон жижиглэн худалдаа	14,658,583.16	9,099,314.05	7,222,196.52	16,535,700.69	7.5%
8	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	2,923,165.18	1,059,345.27	688,091.65	3,294,418.80	1.5%
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2,379,375.85	873,694.60	426,458.95	2,826,611.50	1.3%
